

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг биелүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах 9 дүгээр зорилтын 13 арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан тогтоож, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хэрэгжүүлэх зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх, бодит мэдээллээр хангах, тайланг хэлэлцүүлэх зорилгоор ажиллав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар нэгтгэсэн Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын биелэлтийн гүйцэтгэлийн үр дүнг нотлох, холбогдох материал судалгааг ашиглан, асуудал хариуцсан нэгжээс тайлбар, нэмэлт тодруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулан бататгаж, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг үндэслэн удирдлага, зохион байгуулалтын болон оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан үнэлэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн жилийн эцсийн байдлаарх Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэхээр тусгагдсан 9 зорилтын 13 арга хэмжээний биелэлтийг хяналтад авч, хэрэгжилтийн гүйцэтгэлд үнэлгээ өгөв.

2017 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл 95.4 хувь буюу 4.77 оноотой, 11 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүнтэй”, 2 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” дүнтэйгээр бүрэн хэрэгжсэн дүгнэгдэв.

Дөрөө. Дүгнэлт

1. 2017 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл 95.4 хувь буюу 4.77 оноотой, 11 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүнтэй”, 2 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” дүнтэйгээр бүрэн хэрэгжсэн дүгнэгдэв.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт улсын болон орон нутгийн төсвөөс 11.65 тэрбум төгрөг төсөвлөсөнөөс 2017 он жилийн эцсийн байдлаар 10.0 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Тав. Зөвлөмж

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн 2017 оны жилийн эцсийн байдлаарх Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд ажлын төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, хэрэгжилтэд анхаарч, дотоод хяналтад авснаар тодорхой үр дүнд хүрч, бүрэн хэрэгжсэн боловч цаашид анхаарах шаардлагатай санал, зөвлөмжүүдийг томъёолбол:

1. Монгол улсын эдийн засаг, санхүүгийн байдлаас шууд хамаарах арга хэмжээ төлөвлөснөөр санхүүжилт, хөрөнгө оруулалтаас хамаарч тухайн жилд хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгох, Монгол улсын төсвийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид зайлшгүй тусган, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах шалгуур үзүүлэлтийг нарийвчлан шинэчлэн тогтоох,

2. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан улсын хэмжээний нэгдсэн үнэлгээ тайланг дүгнэх, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтэд үр дүнг ил тод тайлагнах, хэрэгжүүлэх үндэслэл боломжуудыг тусгах,

3. Хэрэгжүүлэгч нэгжүүдийн бүтцийн өөрчлөлтөөс хамааран үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтуудыг дахин нарийвчлан хянаж, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээг зорилтод чиглүүлэх, нэмэлт өөрчлөлтөөр тухай бүр засч сайжруулах боломжийг бүрдүүлэх, тогтолцоог нэвтрүүлэх,

4. Зорилт, арга хэмжээ нь тухайн цаг үеийн болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй үр дүнд суурилсан, биелэгдэхүйц, ач холбогдолтой байх шаардлагатай бөгөөд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах,

5. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн өмнөх жилүүдийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн санхүүжилтийн эх үүсвэрийг зайлшгүй шийдвэрлэн хэрэгжүүлснээр гүйцэтгэл, биелэлтийн үр дүнд гарах эерэг нөлөөллийг судлан тусгах санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

		Хүснэгт-1	
Д/д	Зорилтууд	Хэрэгжилт /хувь/	
9.1	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг сайжруулах	100%	
9.2	Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулах	100%	
9.3	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтын арга хэмжээг сайжруулах	100%	
9.4	Гидрогеологийн хайгуулын судалгаа хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэх	Гидрогеологийн судалгааны ажлын хэтийн төлөвлөгөөний чиглэлийн дагуу Дундговь аймагт ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг хийх, Судалгааны ажлын үр дүнг хүлээн авч, усны нөөцийг баталгаажуулах	100%
		Зураг төсөв нь бэлэн болсон хөв цөөрмүүдийг аймгуудад барьж байгуулах	100%
		Булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг зохион байгуулах	100%
9.5	Түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх замаар агаарын чанарыг сайжруулах	100%	
9.6	Ойг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх ажлыг чанаржуулж, хүлэмжийн хийн шингээх чадварыг нэмэгдүүлэх	Ойжуулах, ойн зурвас байгуулах талбайн хэмжээ	100%
		Хөнөөлт шавьж, өвчний тархалтыг хязгаарлах ажил гүйцэтгэх талбайн хэмжээ, мян.га	100%
		Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мян.га	100%
9.7	Аялал жуулчлалын төв замын дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор төвийн ТЭЗҮ-ийг боловсруулах	100%	
9.8	Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох	70%	
9.9	Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажилд иргэд, олон нийтийн оролцоо, үйл ажиллагааг дэмжиж ажиллах	70%	
Биелэлтийн дундаж үнэлгээ		95.4%	
Оноо		4.77	

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР